



**БУЛГАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас: 7034-2680, Факс: 7034-2565  
Цахим шуудан: [www.info@bulgan.gov.mn](mailto:www.info@bulgan.gov.mn)  
Цахим хуудас: [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn)

2025.11.14 № 01/1887

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т \_\_\_\_\_

Г **БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлж байна.

Хавсралт 2... хуудастай.



Д.ПҮРЭВ-ОЧИР

0375050393

Сугар Ажил 2025 өдөр бүр

**БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС ӨГСӨН  
ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

д/д	Зөвлөмж, албан шаардлага	Хэрэгжилт	Хувь, %
1	2	3	4
1	Аймгийн Байгаль хамгаалах сангийн 2013, 2014 онд үүссэн 110,4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг сум, аж ахуйн нэгжтэй тооцоо нийлж, зөрчлийг арилгах (албан шаардлага)	Аймгийн Байгаль хамгаалах санд бүртгэлтэй 2013, 2014 онд үүссэн 110,4 сая төгрөгийн авлага нь тухайн үед мөрдөгдөж байсан журмын заалттай холбоотой үүссэн бөгөөд ойгоос хэрэглээний мод бэлтгэсэн аж ахуйн нэгжүүд ойжуулалт, нөхөн сэргээлт хийх арга хэмжээтэй холбоотой үүссэн авлага юм. Иймд аймгийн Байгаль хамгаалах санд бүртгэсэн авлагыг сумдад шилжүүлж, холбогдох сумдыг аж ахуйн нэгжтэй тооцоо нийлж зөрчлийг арилгуулах шийдвэр гаргахаар аймгийн Байгаль орчны газраас холбогдох тайлбарыг аваад байна.	70%
2	Аймгийн Байгаль хамгаалах сан, Орон нутгийн Халамжийн сан, Ингэт дел ОНӨААТҮГазрууд санхүүгийн программаар тайлан бэлтгээгүй (зөвлөмж)	Аймгийн Байгаль хамгаалах сан, Орон нутгийн Халамжийн сангийн 2025 оны батлагдсан төсөвт багтаан санхүүгийн программ хангамж худалдан авах боломжтой байна. Ингэт дел ОНӨААТҮГазрыг 2025 оны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн программаар бэлтгэхийг зөвлөсөн.	70%
3	Аймаг, сумдын ОНӨААТҮГ-ууд аж ахуйн тооцооллоор санхүүгийн тайланг бэлтгээгүй (зөвлөмж)	Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01/1562 тоот албан бичгээр орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн программ ашиглан Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэхийг зөвлөсөн.	100%
4	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж хугацаанд нь мэдээлж ажиллах (зөвлөмж)	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт 99 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлсэн. Аймгийн хэмжээгээр 2025 оны 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны мэдээллийн ирц 98,6% байна.	90%
5	Төсөвтэй холбоотой хууль тогтоомж, журам зааврыг мөрдөх, төсвийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах	Төсвийн орлогыг бодитой төлөвлөж бүрэн төвлөрүүлэх, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, өр авлагыг бүрэн барагдуулж, шинээр өр авлага үүсгэхгүй, төсвийн сахилга батыг хангаж ажиллах, 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “өөрчлөлтгүй” санал дүгнэлттэй аудитлуулахыг аймгийн ИТХ-ын Х172 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах бүх шатны төсвийн захирагч нарт даалгалаа. Мөн аймгийн Засаг	

		<p>даргын 2025 оны 01/1563 тоот албан бичгээр аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн захирагч нарт үүрэг болгосон. Санхүү, бүртгэлийн ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх, 2025 оны санхүүгийн тайланг алдаа зөрчилгүй гаргах, төрийн сангийн удирдлагын цахим системийн шинэчлэл, сайжруулалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчлэл, цахим дэлгүүрээс худалдан авалт хийх зааварчилгаа, 2025 оны төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, анхаарах асуудлуудаар найман удаагийн сургалт, зөвлөгөө, мэдээллийг танхим болон цахимаар хийсэн байна. Сургалтад төсвийн шууд захирагч, нягтлан бодогч, сумын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нярвууд хамрагдсан.</p>	100%
6	<p>Орон нутгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө орлогын бааз, суурь судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан төлөвлөх, төлөвлөж батлуулсан орлогыг нэр төрөл бүрээр төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Төсвийн орлогын 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэн тооцооллоо. Аймгийн ИТХ-ын 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн Х/72 тоот тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны 01/1563 албан бичгээр төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлж ажиллахыг төсвийн захирагч, мэргэжлийн байгууллагуудад даалган ажиллаж байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар улс, орон нутгийн төсөвт 57.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 58.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг 101.9 хувь буюу 1.1 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.</p>	100%

## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС